



**ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 07

Зуунмод

**Аргалант сумын хилийн цэсэд өөрчлөлт
оруулах санал уламжлах тухай**

Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын өргөн мэдүүлсэн Нийслэлтэй хил залгаа Аргалант сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах тухай санал, мэдээлэл, түүнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Монгол Улсын засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 3-р хавсралтын 20 дахь зүйлийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Төв аймгийн Аргалант сум, Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгтэй хиллэх хилийн цэсэд өөрчлөлт оруулан шинэчлэн тогтоолгох саналыг дэмжиж Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай.

2. Төв аймгийн Аргалант сум, Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгтэй хиллэх хилийн цэсэд өөрчлөлт оруулан шинэчлэн тогтоолгох саналыг нэгдүгээр хавсралтаар, Аргалант сумын нутаг дэвсгэрт оруулах өөрчлөлтийн тооцоог хоёрдугаар хавсралтаар, Аргалант сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах нутаг дэвсгэрийн газрын зургийг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Аргалант сумын хилийн цэсийг шинэчлэн тогтоолгохтой холбоотой материалыг “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 2 дахь зүйлийн 19-д заасны дагуу бүрдүүлж газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлэхийг аймгийн Засаг дарга (Д.Мөнхбаатар)-д даалгасугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЖАМБАЛСҮРЭН



0100013

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021 оны 06 сарын 28 -ны өдрийн
4 дугаар хуралдааны 07 дугаар
тогтоолын 01 дүгээр хавсралт

**АРГАЛАНТ СУМЫН ХИЛИЙН ЦЭСИЙГ
ШИНЭЧИЛЭН ӨӨРЧЛӨХ САНАЛ**

№	Хилийн цэсийн тоотын нэр	Өргөрөг /WGS84/	Уртраг /WGS84/
1	Их цав хангай /1448.9 тоот/	47°56'12.5900"	105°41'22.7000"
2	Цавын ухаагийн хойт үзүүрийн толгой	47°55'42.4900"	105°44'24.5900"
3	Шаржин уул/1382.0 тоот/	47°56'48.7900"	105°47'47.1000"
4	Аргал уул /1596.5 тоот/	47°58'12.2000"	105°56'22.9900"
5	Пунцагсан /1502.2 тоот/	47°59'43.2000"	106°01'01.4900"
6	Буучийн худаг	47°59'35.5900"	106°03'26.9000"
7	Дулаан уул /1595.5 тоот/	47°58'34.4900"	106°13'35.6000"
8	Бүүргэнтийн 1561.4 тоот	47°59'38.9000"	106°20'10.3900"
9	1558.6 тоот	47°58'58.7900"	106°24'12.1000"
10	Их булгийн адаг /1483.0 тоот/	47°58'50.7900"	106°28'51.8000"
11	1552.0 тоот	47°57'18.2900"	106°31'38.4900"
12	1353.0 тоот	47°56'46.3000"	106°30'23.7900"
13	1497.0 тоот	47°54'38.6000"	106°32'00.5900"
14	1551,0 тоот	47°53'59.95"	106°33'0.031"
15	1551,0 тоот Эмээлт уул	47°51'57.28"	106°33'55.46"
16	1652,3 тоот Сонгино хайрхан уул	47°51'4.402"	106°36'48.02"
17	1584.4 тоот	47°51'48.1000"	106°27'34.1900"
18	Налгар уул /1830.2 тоот/	47°51'11.5900"	106°18'26.7000"
19	Баян толгойн овоо /1674.6 тоот/	47°48'58.5900"	106°10'20.3900"
20	Бор харгана уул /1715.4 тоот/	47°47'16.6000"	106°01'32.8000"
21	Тариатын даваа /1448.0 тоот/	47°43'58.8900"	105°54'02.5900"
22	1694.7 тоот	47°42'31.6900"	105°53'46.6000"
23	Хөшөөтийн худаг	47°44'47.5000"	105°51'07.1900"
24	Тоост уул /1556.8 тоот/	47°45'57.2900"	105°49'43.3900"
25	Шар чулуутын ухаа /1472.6 тоот/	47°48'47.7900"	105°46'05.7000"
26	Өндөр хар ямаат /1380.7 тоот/	47°50'47.4000"	105°42'59.9900"
27	Бага хар ямаат /1314.9 тоот/	47°52'37.0000"	105°41'12.1900"
28	Бүдүүн дугар /1234.2 тоот/	47°54'08.1900"	105°38'23.2900"

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021 оны 06 сарын 28 -ны өдрийн
дугаар хуралдааны 07 дугаар
тогтоолын 06 дугаар хавсралт

АРГАЛАНТ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРОХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТООЦОО

/Талбайн хэмжээ га-аар/

№	Сумын нэр	Одоо байгаа /га/ Аймгийн ГНС тайлангаар	Өөрчлөлтөөр нийт талбай	Нэмэгдэх, хасагдах талбай	Хөдөө аж ахуй газар га-аар	Хот тосгон бусад суурины газар	Усан сан бүхий газар	Ойн сан бүхий газар	Зам шугам сүлжээний газар	Улсын тусгай хэрэгцээ газар га-аар
1	Аргалант сум	112637,0	114680	+2043	89739.8719	1180.4164	13	1253	1239.2500	19211.46
	Сонгино хайрхан дүүрэг			-2043						
	НИЙТ		114680		91782.87	1180.4164	13	1253	1239.2500	19211.46

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021 оны 06 сарын 28 ны өдрийн
1 дугаар хуралдааны 07 дугаар
тогтоолын 03 дугаар хавсралт

Аргалант сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах нутаг дэвсгэрийн газрын зураг

